

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын сангийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/21/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413	Цахим хаяг: Tuvshinbayarkh@audit.gov.mn
Алтай хот	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484030	Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn
2022 он	Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546	Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn
	Аудитор: Б.Цэвэлмаа Утас: 99026016	Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/	8
3. Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	10
3.5.1 Орлогын данс	11
3.5.2 Зардлын данс	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Л.ЭНХЖАРГАЛ ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 189

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын сангийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын сангийн төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй

07020534

баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		7,587,425.9	9,170,131.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	4,205,665.7	4,215,452.8
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	3,364,596.0	4,941,139.6
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	17,164.2	13,538.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		753,969.6	723,708.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	753,969.6	723,708.9
39200	Биет хөрөнгө		748,089.6	717,828.9
39300	Биет бус хөрөнгө	13	5,880.0	5,880.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		8,341,395.5	9,893,840.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		75,274.9	97,397.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	75,274.9	97,397.2
41300	Өглөг	17а, 17б	12,269.2	8,500.7
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	63,005.6	88,896.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		8,266,120.6	9,796,443.0
51	Засгийн газрын хувь оролцоо		8,266,120.6	9,796,443.0
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		213,758.4	213,758.4
51200	Хуримтлагдсан үр дүн		8,052,362.3	9,582,684.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		8,341,395.5	9,893,840.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		49,856,393.1	48,671,439.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО		23,145,312.3	24,575,459.2
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		23,145,312.3	24,575,459.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	69,357.5	29,598.4
120	Нийтлэг татварын бус орлого		69,357.5	29,598.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		26,641,723.3	24,066,382.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	44,900,036.6	47,169,457.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		44,900,036.6	47,169,457.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		704,485.5	691,578.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		486,901.2	485,495.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		62,861.8	64,460.0

Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын сангийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		32,315.0	34,733.0
2104	Хангамж, бараа материалын зардал		25,411.1	22,149.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,875.7	2,474.0
2107	Томилолт, зочны зардал		4,704.5	2,550.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		28,028.0	27,790.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		59,388.1	51,925.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		44,195,551.1	46,477,879.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		4,956,356.6	1,501,982.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	428.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		4,956,356.6	1,502,410.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		47,139,659.1	47,224,686.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО		20,685,611.1	23,061,555.1
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		20,685,611.1	23,061,555.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		117,808.6	62,442.1
120	Нийтлэг татварын бус орлого		117,808.6	62,442.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		26,336,239.4	24,100,688.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		44,983,120.2	47,214,898.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ		44,983,120.2	47,214,898.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		649,632.2	644,486.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		486,901.2	485,495.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		62,861.8	64,498.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		32,315.0	34,733.0
2104	Хангамж, бараа материалын зардал		24,768.1	21,554.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,925.7	2,474.0
2107	Томилолт, зочны зардал		4,704.5	2,550.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		31,857.4	31,185.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,298.5	1,995.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		44,333,488.0	46,570,412.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		2,156,539.0	9,787.1
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		2,156,539.0	9,787.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,049,126.7	4,205,665.7

20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,205,665.7	4,215,452.8
----	---	--	-------------	-------------

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,285,664.8	3,285,664.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	24,099.3	24,099.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,309,764.1	3,309,764.1
9	Тайлант үеийн үр дүн	4,956,356.6	4,956,356.6
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,266,120.6	8,266,120.6
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,266,120.6	8,266,120.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	27,911.9	27,911.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,294,032.5	8,294,032.5
19	Тайлант үеийн үр дүн	1,502,410.4	1,502,410.4
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	9,796,443.0	9,796,443.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,169,690.6	42,715,050.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,169,690.6	42,715,050.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	649,801.4	636,304.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	496,331.2	485,495.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,535.7	64,498.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,819.0	34,733.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21,579.6	21,554.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500.0	2,474.0
2107	Томилолт, зочны зардал	2,751.4	2,550.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,284.5	23,003.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000.0	1,995.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,519,889.2	42,078,745.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,519,889.2	42,078,745.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	43,169,690.6	19,479,202.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,359,186.8	41,087.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,810,503.8	19,431,436.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	6,679.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,205,665.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,215,452.8
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	41.00	39.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00

620002	Гүйцэтгэх ажилтан	35.00	33.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	285.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	285.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	285.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	285.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	285.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэвэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын сан нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 80 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулах зэрэг чиг үүрэгтэй Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газар, Хяналт шалгалтын газраас шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын сан нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 44,900.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 898.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 718.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 47,169.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 943.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 754.7 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-ын 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16 хувиар буюу 1,552.4 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 4,205.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,215.4 сая төгрөг болж 9.7 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээс 4,213.7 сая төгрөг нь арилжааны банкинд, 1.8 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 3,364.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,941.1 сая төгрөг болж 1,576.5 сая төгрөгөөр өссөн нь татаас санхүүжилтийн авлага, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага нэмэгдсэнтэй холбоотой. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын 1,062.1 сая төгрөг нь тайлант онд үүссэн, 844.0 сая төгрөг нь өмнөх онуудад үүссэн, нэгээс дээш жилийн насжилттай авлага байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 17.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 13.5 сая төгрөг болж 3.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 21.3 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 1.6 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 26.5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 13.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,000.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 972.2 сая төгрөг болж 28.3 сая төгрөгөөр буурсан нь 5.6 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолоор үнийг шинэчлэн тогтоосон 14.0 сая төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож данс бүртгэлд тусгаж, 48.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Өр төлбөрийн дансны эхний үлдэгдэл 75.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 97.4 сая төгрөг болж 22.2 сая төгрөгөөр өссөн урьдчилж орсон орлогын өсөлтөөс голчлон шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны эхний үлдэгдэл 8,266.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9,796.4 сая төгрөг болж 1,530.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 2 хувиар буюу 1,185.0 сая төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын өсөлттэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 27.9 сая төгрөгийн бичилт хийгдсэн ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 9,582.7 сая төгрөг болсон байна.

3.5.1 Орлогын данс

Тайлант онд 24,575.5 сая төгрөгийн татварын орлого, 29.6 сая төгрөгийн татварын бус орлого, 24,066.4 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 48,671.4 төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.5.2 Зардлын данс

Тайлант онд 47,169.5 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

3.5.3 Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/175 дугаар тушаалаар нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 24,821.4 сая төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр 23,061.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж 1,759.8 сая төгрөгөөр тасарсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 875.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 144.0 сая төгрөгөөр бууруулж, 731.9 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс бага байгаа нь цалингийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал зэргийг бууруулсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 8 арга хэмжээг улсын төсөв, нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр 43,169.7 сая төгрөгийн төсөв баталснаас 731.9 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд, 42,437.8 сая төгрөгийг сангийн үйл ажиллагаанд зарцуулахаар байна.

Гүйцэтгэлээр 731.9 сая төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч, төлбөртэй үйлчилгээний хураамж 0.6 сая төгрөг төвлөрүүлж, үйл ажиллагаанд 720.2 сая төгрөгийг зарцуулж 12.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 720.2 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь цалин, хөлс нэмэгдэл урамшууллыг 10.8 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.09 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 0.2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 0.5 сая төгрөгөөр, тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Тайлант онд нийгмийн даатгалын санд гүйцэтгэлээр 41,788.0 сая төгрөгийн санхүүжилт, орлого олж, үйл ажиллагаанд 41,358.5 сая төгрөгийг зарцуулж 4,450.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 0.03 сая төгрөгийн орлого хүлээн авч, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 137 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 11 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой

Түүвэрт хамрагдаж байгаа байгууллагууд нь тайлант онд аж ахуйн нэгж, байгууллагаас худалдан авалт хийхдээ и-баримтгүй 3.4 сая төгрөгийн гүйлгээ хийснийг аудитын явцад төлбөрийн баримтыг нөхөн шивүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасан заалттай нийцэж байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 34.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын барагдуулалтыг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 1 төсвийн байгууллага, 1 тусгай сангийн нийт 2 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 15.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7.5 сая төгрөгийн алдааг залруулж, 8.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Татварын тодорхойлолтоор 0.2 сая төгрөгийн дутуу, 3.8 сая төгрөгийн илүү төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байсныг аудитын явцад тооцоо нийлж залруулсан. Мөн зардлыг түүвэрлэн үзэхэд 3.4 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийснийг нөхөж шивүүлсэн.

4.2 Төвлөрүүлэн захирагчийн төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоосон алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.3 Төвлөрүүлэн захирагчийн албан шаардлага

Сумдын байцаагч нарт олгосон 3.3 сая төгрөгийг тээвэр шатахууны тооцоо бодоогүй, жолоочийн тооцооны хуудасгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Монгол улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар

тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 0.2 сая төгрөгийн дутуу, 4.7 сая төгрөгийн илүү төлөлт татварын цахим системд бүртгэлтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" , 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайланд нэгээс дээш жилийн насжилттай 844.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага бүртгэлтэй, барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Зөвлөмж өгөх алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/											
д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
	Нийгмийн даатгалын сангийн Төвлөрүүлэн захирагч	5	15.7	2	7.5			3	8.2		
	Дүн	5	15.7	2	7.5			3	8.2		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Нийгмийн даатгалын сангийн Төсвийн төвлөрүүлэн захирагч	1						1			
	Дүн	1						1			
	Нийт дүн	6	15.7	2	7.5			4	8.2		